



ОРХОН АЙМГИЙН СОНГУУЛИЙН
ХОРООНД

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.07.31 № 273
танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох ШИНЭ намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 – 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 – 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай

хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

ШИНЭ намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр  хуудсыг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРМАНДАХ





“ШИНЭ СОНГОЛТ-ШИНЭ МОНГОЛ”

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ийн
хурлын сонгуулийн
мөрийн хөтөлбөр - 2024

/ОРХОН АЙМАГ/



Улаанбаатар хот 2024 он

ОРХОН АЙМАГ

1. Эрчимжсэн МАА, малын тэжээлийн үйлдвэрлэл хосолсон нэгдсэн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж буй аж ахуй нэгж байгууллага иргэдийг дэмжинэ.
2. Зах зээлд өндөр үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүнийг нийлүүлэх хүлэмжийн аж ахуй болон бусад ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжинэ
3. Арьс шир, хүнс болон бусад үйлдвэрлэлийг төгөлдөржүүлэн, хөгжүүлэх иргэд аж ахуйн нэгж байгууллагыг дэмжинэ
4. Эрдэнэт хотыг төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх болон Улаанбаатар, Хөвсгөл, ОХУ чиглэлийн аялал жуулчлалын түшиц газар болгон хөгжүүлэхийг зорьж дэмжин ажиллана
5. Соёлын болон эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлийг дэмжинэ.
6. Ногоон байгууламжтай, амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, уурхайн нөхөн сэргээлт, арчилгаатай загвар уурхай болгон хөгжүүлэх чиглэлээр иргэд байгууллагатай хамтран ажиллана

